



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/03

Батширээт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд хуш модны самар бэлтгэх гэрээтэй ажилладаг ойн мэргэжлийн байгууллага “Омни перфект”ХХК-ийн захиалгаар 13 га талбайд ойжуулалт хийсэн “Оргил сарьдаг уул”ХХК-ийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Төрмөнх – Засаг даргын орлогч
Гишүүд: Б.Мөнх-Очир – Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
Г.Гантуяа – Ойн ангийн дарга
Б.Болд- Байгаль хамгаалагч
Б.Мэндбаяр- Идэвхтэн байгаль хамгаалагч

2. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, баримтжуулан актаар хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д хариуцуулсугай.

3. Намрын улиралд амьдралтын хувийн түвшинг тогтоон үр дүнг тооцон ажиллахыг сум Дундын Ойн ангийн дарга (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



2025.05.19